



СТРАТЕГИ СУДАЛГААНЫ
ХҮРЭЭЛЭН

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, СТРАТЕГИ ТОЙМ


Дугаар №16 2023/04

ДУГААРЫН АГУУЛГА

- Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж, чанар цаашдын хандлага
- Дайны хувьсал, өөрчлөлт
- Сүүлийн үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, онцлог
- Цэргийн зэвсэг, техник, технологийн хөгжлийн цаашдын чиг хандлага
- Дүгнэлт

Цахим хуудас:
www.iss.gov.mn

ОРЧИН ҮЕИЙН ДАЙНЫ ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ, ЗЭВСЭГЛЭЛ ТЕХНИКИЙН ХӨГЖИЛ



ДАЙН: - хосолмол - хүч тэнцвэргүй

- кибер МЭДЭЭЛЛИЙН

- цогц

- цөмийн - бослого эсэргүүцлийн дайн

- саарал бүсийн

- төлөөллийн

ОРШИЛ

Хүн төрөлхтний соёл иргэншлийн 5,5 мянга орчим жилийн хугацаанд 15 мянга гаруй дайн болж өнгөрсөн байдаг. Дайн бүр улс төр, цэрэг-стратегийн зорилго, дайтагч тал (цэргийн эвсэл, холбоотон), хэмжээ далайц, удирдсан жанжин, шинээр хэрэглэсэн (ашигласан) зэвсэг, техник, байлдааны ажиллагааны арга тактик, цэргийн бэлтгэл зэрэг маш олон хүчин зүйлээс хамааралтай, өөр өөрийн онцлог шинж чанарыг агуулсан байдаг. Дайны бас нэгэн гол онцлог нь өмнөх дайн дараагийн дайны туршлага, сургамж болж ирсэн залгамж чанартай, тухайн үеийнхээ оюун ухааны дэвшил, шинжлэх ухаан, технологийн шинэ ололтыг хамгийн түрүүнд туршиж, ашиглаж байдагт оршино.

Өнгөрсөн XX зуунд дэлхийн I, II дайн, Солонгосын, Вьетнамын, Араб - Израилын, Афганистанын, Персийн булангийн дайн гэх мэт цэрэг-улс төрийн зорилго, шинж чанарын хувьд ялгаатай хэд хэдэн том дайн болсон билээ. Дэлхийн II дайны дараа эхэлсэн дайн, зэвсэгт мөргөлдөөнүүд нь сөргөлдөгч капиталист, социалист хоёр системийн дэлхийг хуваах гэсэн геополитикийн сөргөлдөөнөөс улбаатай цэрэг-стратегийн ил, далд тэмцэл, цэргийн онол, шинэ зэвсгийн туршилтын талбар байсан гэж болно.

Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд болж өнгөрсөн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлагаас улс орнуудын аюулгүй

байдлын бодлого, цэргийн стратеги, шинэ зэвсэг, техник, технологийн хөгжил, цэрэг дайны салбарт хэрхэн тусгалаа олж байсныг харж болно. Тухайлбал, урьд өмнө хэрэглэж байгаагүй шинэ төрлийн зэвсгийг Солонгосын дайн (1950-1953)-ы үед 9, Вьетнамын дайн (1964-1975)-ы үед 25, Ойрх Дорнодын зэвсэгт мөргөлдөөн (1967, 1973, 1982, 1986)-ий үед 30, Персийн булангийн дайн (1991)-ы үед 100 гаруйг туршиж, хэрэглэсэн байдаг. Шинэ зэвсгийн хэрэглээ нь дайны шинж чанарт өөрчлөлт оруулаад зогсохгүй дараагийн болзошгүй дайны шинж чанарыг тодорхойлох өгөгдөхүүн болдог.

1

ОРЧИН ҮЕИЙН ДАЙН, ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ШИНЖ ЧАНАР, ЦААШДЫН ХАНДЛАГА

Цэргийн аюулгүй байдлыг хангах онолын хөгжил нь тухайн орны засаглалын чадамж, нэгдмэл улс төрийн бодлого, эдийн засгийн чадавх, цэрэг армийн

хүчин чадлаас хамааралтай бөгөөд улс орны үндэсний аюулгүй байдлын эрх, ашиг сонирхлыг цэргийн хүч хэрэгслийн оролцоотойгоор хангах боломжоор тодорхойлогддог. Улс

орнууд ирээдүйн шинэ аюул, сорилтын хүрээнд шинэ дайны онолыг судлах үйл явц ихээхэн өрнөж, цэргийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаандаа анхаарах болов.

Шинэ зэвсэглэл техник, технологи нэвтрэхийг дагаад цэргийн шинжлэх ухаан өөрөө хөгжиж, аюулгүй байдлаа хангах арга замууд ч боловсронгуй болсоор байна.

Цэргийн аюулгүй байдлыг хангах онол нь гадаад, дотоод орчны өөрчлөлт, нөлөөлөх хүчин зүйлээсээ болоод тодотгогдож, өөрчлөгдөж байдаг түүний шинжлэх ухаанч чанар оршдог төдийгүй энэ нь философи, нийгэм судлал, улс төр, олон улсын харилцаа, эдийн засгийн салбартай хамаарал бүхий үндэсний аюулгүй байдлын судлагдахуун гэж үздэг хандлага ч зарим улс оронд бий.


Улс орнуудын харилцаа улам бүр, өргөн цар хүрээг хамарч, эдийн


засаг, мэдээлэл, техник технологийн харилцан хамааралтай болж, шинэ аюул, сорилтууд бий болж байгаа зэрэг нь цэргийн аюулгүй байдлыг цэргийн шинжлэх ухааны хүрээнд авч үзэхээс хальж, улс төр, олон улсын харилцаа, эдийн засгийн асуудлуудтай уялдуулан нэгдсэн цогц байдлаар аюулгүй байдлын шинжлэх ухааны хүрээнд авч үзэж судлах шаардлагыг буй болгоод байгаа юм. Цэргийн аюулгүй байдлыг хангах асуудал нь өөрөө нарийн төвөгтэй нэг мөр шийдвэрлэх боломж нь олон хүчин зүйлээс хамаарч хязгаарлагдмал байдаг онцлогтой. Цэргийн аюулгүй байдал судлалын ойлголт нь бусад шинжлэх ухааныхтай тодорхой хэмжээгээр адил төстэй байх боловч, цэргийн

шинжлэх ухааны өөрийн ойлголтын онцлог категори, ойлголтуудтай байдаг юм. Тухайлбал, улс орны ЦАБ-тай холбоотой үндсэн категориуд болох цэргийн аюул, заналхийлэл, дайн, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн ажиллагаа, уламжлалт болон уламжлалт бус аюул гэсэн цэргийн шинжлэх ухааны ойлголтуудыг хэрэглэдэг бөгөөд тэдгээрийг зөв тодорхойлж ойлгох нь батлан хамгаалах, цэргийн бодлогыг боловсронгуй болгох практик үйл ажиллагаанд үр дүнтэй нөлөө үзүүлдэг.

Өдгөө цэргийн хэргийн онол, үзэл баримтлал, арга зүйд томоохон хувьсал, өөрчлөлт гарч, улс орны ЦАБ-ыг хангах үндсэн үйл ажиллагаа, үйл явцад дараах байдлаар нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна.

Зураг 1. Цэргийн хэргийн онолын хувьсал өөрчлөлт





Ийнхүү цэргийн аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, арга зүйд томоохон өөрчлөлт

гарч, түүнийг хангах үндсэн үйл ажиллагаа нь ЦАБ-д нөлөөлж буй аюул, эрсдэлийн чиг хандлагын

судалгаа, дүн шинжилгээ, үнэлгээ гэж үзэж болохоор байгаа юм.

Цэргийн хэргийн онолын хөгжлийн ерөнхий хандлага

Цэргийн хэргийн хөгжил хурдтай явагдаж, тэргүүлэгч гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр эрчимжиж байна. Цэргийн хэргийн дараагийн ээлжийн ямар хувьсал биднийг хүлээж байна вэ? Автоматчлагдсан, кибер, хиймэл оюун ухаантай, роботик, том өгөгдөл, дрон бүхий дайны ажиллагаа ямар үр дагавар авчрах вэ? гэдэг анхаарах асуудал болж байна. Өнөөгийн нөхцөл байдлыг харахад цэргийн хэрэгт дараах хандлага ажиглагдаж байна. Үүнд:

- Хүний ажиллаж, амьдрах орчин өөрчлөгдөж байгаагаас дайн болох орон зай ч түүнийг дагалдан хувьсаж байна. Нийгмийн болон хүний хөгжил хаашаа явж байна дайн тийш хөгжиж, дайн болж буй газар орон зай, явуулах хэрэгсэл, оролцогч, хурд, нөлөө, хамрах хүрээ, учруулах хохирол бүгд хурдтай өөрчлөлтөд байна.
- Байлдааны талбарт ялалт байгуулах, дайнд ялах гэдэг хоёр өөр зүйл болсон байна. Байлдаан, тулаанд ялсан ч дайнд ялагдаж байна. Дайнд ялсан ч улс орны хувьд стратегийн ялалт байгуулж чадахгүй нөхцөл байдал үүсэж байна.
- Дайныг улс орнууд улс төр, дипломат, мэдээлэл, цэрэг, эдийн засаг гээд бүх арга хэрэгслийг ашиглан

хосолмол явуулах болсон байна.

- Улс хоорондын дайн болон улс доторх зэвсэгт тэмцэл гарах магадлал хэдийгээр дэлхийн II дайнаас хойш буурч байгаа ч геостратегийн ашиг сонирхол, стратегийн нөөцийн төлөөх тэмцэл, эдийн засгийн хямрал,

тэсрэлт үүсгэсэн технологи нь аюулын эрсдэлт байдлыг буй болгож, илүү үхлийн аюултай зэвсэглэл, технологиуд улс бус тоглогч, сөрөг талын гарт очих магадлал байсаар байна.

- Цөмийн дайн ахин эрсдэл болон гарч ирж байгаа бөгөөд дэлхийн II дайнаас

хойш хамгийн хүнд нөхцөлдөө орж байна. Иран, Саудын араб, Хойд Солонгос гээд цөмийн зэвсэгтэй улс нэмэгдэх эрсдэл бий болсон.

- Дайн улам бүр алсын зайн нэн өндөр цэцгэж зэвсэглэлийн цохилтод тулгуурлах хандлага байна.

2

ДАЙНЫ ХУВЬСАЛ, ӨӨРЧЛӨЛТ

“Дайн бол өөрийн хүслийг нөгөө талдаа хүчирхийллийн аргаар тулган хүлээлгэх ажиллагаа”, “Дайн гэдэг нь өөр хэрэгслээр явуулж буй улс төр” гэж 1800-аад оны эхээр амьдарч байсан Пруссийн генерал, дайны онолч Карл Вон Клаусвич “Дайны тухай” номдоо бичсэн байдаг. Энэ номлол өнөөдөр ч хүчин төгөлдөр байна. Өрсөлдөөнөөс сөргөлдөөн, сөргөлдөөнөөс мөргөлдөөн, зэвсэгт тэмцэл, зэвсэгт тэмцлээс дайн гэсэн шатаар дайны хүрээ өргөжиж тэлдэг. Аливаа улс, үндэстэн, тэдгээрийн эрх баригч, удирдагчдын дайны мөн чанарын талаарх ойлголт нь дайныг хэрхэн явуулах үзэл баримтлал,

сургаал, номлол, стратегийг хэрхэн боловсруулах, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, байлдааны зэвсэг хэрэгслээр хангах зэрэгт шууд нөлөөлж байдаг.


Олон улсын харилцааны онолчид, цэргийн стратегич, удирдагчид дайн, тайван цагийн ялгаа улам бүр алга болж, дайны ажиллагааг уламжлалт цэргийн хатуу хүчээр, тэдгээрийн хооронд явуулах биш бүх хүч хэрэгслээ ашиглан, бүх талбарт явуулах болсон гэдэгтэй санал нэг байна. Үүнд дөрвөн гол үндэслэл байна.

1. Дайныг зөвхөн цэргийн хүчээр биш улс орны бүх төрлийн хүч хэрэгслийг

ашиглан хосолмол аргаар явуулах болж дайны сонгодог утга байхгүй болсон;

2. Эдийн засгийн хувьд ашиггүй дайнд оролцох хүсэл сонирхол аливаа улсад байхгүй болсон;
3. Дайн явуулах хүрээ өргөжиж, уламжлалт дайны талбараас өөр орчинд дайсагналцах болсон;
4. Дайн улам бүр тактик, оперативийн арга хэрэгслээр стратегийн ялалтад хүрэхэд чиглэсэн стратегийн сэтгэлгээний өрсөлдөөн болсон.

Зураг 2. Дайны мөн чанар



1. Дайныг улс орны бүхий л төрлийн хүч хэрэгслийг ашиглан хосолмол байдлаар явуулдаг болов. Сонгодог утгаар дайны зорилго бол улс орон, хүн ам, газар нутгаа бусдын түрэмгийллээс зэвсэгт хүчээр хамгаалах явдал. Барууны номлолоор дайнд DIME гэж тодорхойлох улс орны дипломат, мэдээлэл, цэрэг, эдийн засгийн хүч хэрэгслийг уялдуулан ашиглах болсон. Хамгийн сүүлчийн ердийн дайн 77 жилийн өмнө буюу дэлхийн II дайн дуусахад өнгөрсөн гэж үздэг. Өнөөдөр дайны ажиллагаа дайтагч аль нэг тал нь аливаа улс орны цэргийн хүчин биш дайтагчтай

уламжлалт бус дайны хэлбэр буюу дөрөвдөх үеийн хүч тэнцвэргүй дайн (Asymmetric Warfare), уламжлалт болон уламжлалт бус дайн, цахим дайныг улс төрийн дайнтай хослуулан, хуурамч мэдээлэл, дипломат ажиллагаа, хуулийн ажиллагаа, гадаадын сонгуульд хөндлөнгөөс оролцох зэрэг нөлөөллийн арга хэрэгслийг цогц байдлаар ашиглах хосолмол дайн (Hybrid Warfare), дайтагч улсын эсрэг бодит дайнтай харьцуулахууц хор уршиг учруулах, компьютерын нэн чухал системийг нь сүйтгэх цахим халдлага ашиглах Кибер дайн (Cyber Warfare), дайнд шууд оролцоогүй

бусад талын өмнөөс, эсхүл тэдний турхиралт, өдөөлтөөр хоёр тал, эсхүл аль нэг тал нь дайтаж буй, хоёр улс, эсхүл улс бус тоглогчдын хооронд болж буй төлөөллийн дайн (Proxy Warfare), дайнд иргэний бүх нөөц, дэд бүтцийг хууль ёсны цэргийн цохилтын байж гэж үзэх, дайн хийхэд нийгмийн бүх нөөцийг ашиглах, дайны хэрэгцээг тэргүүн эгнээд авч үзэх Цогц дайн (Total Warfare), атомын дайн ч гэж нэрдэгддэг цөмийн зэвсэг ашигласан Цөмийн дайн (Nuclear Warfare), гол төлөв хөдөө, орон нутагт байрлалтай, хөнгөн зэвсэглэсэн, жижиг бүлэглэлээс эрх бүхий субъектийн эсрэг явуулж

зөрчил (Gray zone conflict) зэрэг олон хэлбэрээр үргэлжлэх болсон. Цэрэг, энгийн нь мэдэгдэхгүй зэвсэглэсэн хүч гэнэтийн байдлаар аливаа улсад нэвтрэх, тодорхой газар нутаг, онц чухал объектыг эзлэн авах болов. Цэрэг, энгийн нь мэдэгдэхгүй зэвсэглэсэн хүч гэнэтийн байдлаар аливаа улсад нэвтрэх, тодорхой газар нутаг, онц чухал объектыг эзлэн авах болов.

Хосолмол дайны үед дайсны армийг бут цохих биш ард түмэн, олон нийт рүү нь чиглэсэн ажиллагаа

идэвхжих болсон байна. Цахим орчин, мэдээллийн орон зайг ашиглан ард түмний тархийг угаах, хооронд нь талцуулах, хагалан бутаргах, нийгмийн ёс суртахууныг нь шалд нь унагаах, төрийн нэр хүндийг ард түмэн дотор үгүй болгох, үйл ажиллагааг нь хүчгүй болгох ажиллагааг хэрэгжүүлэх болсон байна. Энэ үед ямар ч хүчирхэг улс “тос дотроосоо” гэдэг шиг өөрөө хямраад өрсөлдөгч талын мэдэл, нөлөөнд ордог байна.

Ялангуяа зохион

байгуулалттай болон бусад байдлаар худал мэдээлэл тараах ажиллагааг хүчтэй нөлөөлөлтэй явуулах болсон. Худал мэдээллийг асар их хэмжээгээр, өндөр давтамжтайгаар социал болон цахим орчинд цацах, тодорхой зорилгоор зориудаар тухайн улсын амин чухал, эмзэг асуудлыг хөндөж хуурамч мэдээллээр дайралт хийж байна. Сонгуулийн болон нийгмийн тодорхой хурц маргаантай асуудлын үед эдгээрийг илэрхий харж болно. Энэ бол тайван цагт явагдаж буй мэдээллийн дайн юм.

Зураг 3. Орчин үеийн дайны арга, хэлбэр



2. Эдийн засаг нь хямраад улс орон нь ядуураад үлдэх юм бол дайнд ялах, ялсны ашиг, ач холбогдолгүй болж байна. Эдийн засаг уу? аюулгүй байдал уу?

гэдэг шийдвэрийг улс орнууд гаргах ёстой болж байна. Хөгжил цэцэглэл, аюулгүй байдал гэдэг өндөг, тахианы асуулт шиг байнга тавигдах асуудал болсон.

Хоёр улс өндөр зардлаар дайтаж хохирч үлдэхэд гуравдагч улс нь эсрэгээрээ тэндээс хонжоо олж гарч ирдэг жишээ олон болж байна. Дэлхийн I, II дайнд

АНУ хожуухан оролцож, хохирол багатай гарч ирж, өөрт ашигтайгаар хувирган, Их Британийн их гүрний статусыг авсан байдаг.

3. Дайн явагдах орон зай хувирч өөрчлөгдөн тодорхойгүй болов. Сансарын болон цахим орчинд халдлага, зөрчил хурц маргаантай асуудал болж байна. Дайн анх хуурай газар дээр дайн явагддаг байсан бол улмаар усан дээр явагдах болж тэнгисийн цэрэг бий болсон байна. Нисэх хэрэгсэл 1910 он гэхэд бий болсноор агаарт дайн явагдах болж, агаарын хүчин үүссэн. Орчин үед дайн явагдах орчин сансар, цахим орчноор хүрээгээ тэлж, энэ чиглэлийн аюулгүй байдлын хүчнүүд дэлхийн улс орнуудад байгуулагдан үйл ажиллагаа явуулах болов. Дайны талбар гэдэг үгийг хэрэглэхэд бодолтой хандах шаардлагатай болж байна. Агаар, газар, тэнгисийн хүчин тус тусын орон зайд хүч хэрэгслээрээ кинетик буюу устгах хүч агуулсан цохилт өгдөг. Тэгвэл цахим орон зайд кинетик бус буюу

устгаж үхүүлэхгүй ч асар хохиролтой цохилтыг өгөх боломж бий болсон байна. Тухайлбал, 2011 онд Хойд Солонгосын цахим хүчний үйлдсэн гэх АНУ дахь Сони компанийн сүлжээнд нэвтэрсэн халдлага 23 хоног нийт хэрэглэгчийн сүлжээг тасалж, 77 сая хэрэглэгчийн мэдээлэлд нэвтэрч, 170 гаруй сая ам.долларын шууд хохирол болон дагалдан гарах асар олон шүүхийн зарга, маргааныг үүсгэсэн байна. Зөвхөн 2021 онд энэ цахим хүчин 400 сая ам.долларын крипто валют сүлжээнээс хулгайлсан гэж Чэйнанализиз платформоос мэдэгдсэн.

4. Дайн зөвхөн тактик техник, бие бялдар, зэвсгийн мэдлэг чадвар төдий биш стратегийн, сэтгэлгээний бэлэн байдал шаардах болсон. Улс орнууд хамгийн олон хүнтэй, хүчирхэг зэвсэглэлтэй гэж өрсөлдөхөөс гадна ямар ч нөхцөлд өрсөлдөгч талаас илүү оновчтой, хурдтай шийдвэр гаргаж, хэрэгжүүлж чаддаг зэвсэгт хүчний бүрэлдэхүүнтэй болоход анхаарах болсон.

Стратегийн үндсэн зорилго, зорилтоо ойлгож, удирдагчийн шийдвэргүй үед ч хүлээлтгүйгээр тасралтгүй шийдвэр гаргах, үрдүнтэй үйл ажиллагааг бие даан явуулах бүрэлдэхүүн хамгийн чухалд тооцогдож байна. Учир нь ийм бэлтгэгдсэн хүмүүс л өнөөгийн хувьсамтгай, тодорхойгүй, ээдрээтэй, эргэлзээтэй (ХТЭЭ)¹ нөхцөлд улс орныхоо эрх ашгийг хамгаалах боломжтой гэж үзэж байна. Чадварлаг цэргийн бүрэлдэхүүнгүйгээр техник технологид хэт дулдуйдах нь эрсдэл дагуулж, зэвсэгт хүчний чадварт сөрөг нөлөөтэй гэж үзэх болжээ. Хүний хүчин зүйл, онол номлол, стратеги, бодлогоо сайжруулахад анхаарч байна. Орчин үеийн дайнд бэлтгэгдсэн, өрсөлдөгчөөсөө давж сэтгэх бие бүрэлдэхүүнийг бий болгохыг зорьж байна. Зөв хүнийг зөв ажилд нь тавьж ажиллуулах авьяасын менежментийн тогтолцоог цэргийн салбарт түлхүү ашиглах болсон байна.

¹ VUCA-volatility, uncertainty, complexity and ambiguity

Дайны ангилал

Дайныг явагдах орон зай, хурд, хэрэглэж буй технологи, ашиглаж буй арга хэрэгсэл, хамрах талбараар нь гэх мэтчилэн ангилсан байдаг. Судлаач Антоин

Боскүйт дайныг шинжлэх ухааны үүднээс дөрвөн үндсэн чиглэлд хуваасан байна. Эдгээр нь онол, арга зүйн тодорхой нэгдлийн хүрээнд болох 1. механик,

2. термо-динамик, 3. кибернетик, 4. кэоплексик²-

² Chaoplex гэдэг нь Chaos (хямрал, эмх замбараагүй байдал) complex (ээдрээтэй) гэсэн хоёр үгний нийлмэл бөгөөд ирээдүйн дайны шинжийг тодорхойлж буй юм.

ээр тодорхойлогдох юм. Тэрээр энэ бүхний цөмд нь парадигмын өөрчлөлт авчирсан технологи байгаа гэж үзсэн бөгөөд үүнд 1.цаг, 2.хөдөлгүүр, 3.компьютер, 4.сүлжээ гэсэн байна.³

³ Дайны шинжлэх ухааны зам: Орчин үеийн тулааны талбар дахь

Өөрөөр хэлбэл, тэрээр шинжлэх ухаан, технологийн нийгэм дэх бодит үр дүнгээс үндсэн санаагаа авч дайныг ангилан, үүнээсээ орчин үеийн цэргийн байгууллагын

дэг журам ба эмх замбараагүй байдал. 2009. Колумбын Их сургуулийн хэвлэл

алсын харааг гаргаж ирсэн байдаг.

Олонх судлаач дайныг цэргийн үзэл номлол, арга ажиллагаа, технологид гарсан томоохон өөрчлөлтөөр нь зургаан тодорхой үед ангилсныг хүлээн зөвшөөрдөг.

Хүснэгт 1. Дайны хувьсал, өөрчлөлт

Дайны үе	Онцлог	Жишээ
I үеийн дайн	Хүний тоо, хүчин зүйлд тулгуурласан, шугам, эгнээ, газар нутгийг ашиглан байлддаг эртний үеэс XIX зууны дунд үе-үндсэндээ Наполеоны үе хүртэлх дайн, хүн төрөлхтний түүхийн асар их хугацааг эзэлдэг.	<ul style="list-style-type: none"> • 1642 оны Английн иргэний дайн; • 1654 оны Англи-Испанийн дайн; • 1756 оны Долоон жилийн дайн; • 1775 оны Америкийн хувьсгалын дайн; • 1803 оны Наполеоны дайн.
II үеийн дайн	Аж үйлдвэрлэлийн хувьсгалтай холбоотой, автомат буу, нээлттэй болон нууц тактик ашигласан, их буу, зэвсэг илүү чухал болсон, зохион байгуулалт сайжирсан үеийн дайн, моторт тээврийн хэрэгсэл өргөн ашиглагдаж ирснээр энэ үеийн дайн дуусгавар болсон.	<ul style="list-style-type: none"> • 1899 оны Боерын дайн; • Америкийн иргэний дайн; • Дэлхийн нэгдүгээр дайн; • 1936 оны Испанийн иргэний дайн.
III үеийн дайн	XX зууны үеэс зэвсэглэлийн хурд, хүч, нууцлал нэмэгдсэн, агаарын хүчин (онгоц, шүхэрчид), хуягласан зэвсэглэл, механикжуулсан салбар, ангийг ашиглаж, эхэлсэн, маневр хийж бүслэх, гэнэдүүлэх арга тактик ашиглагдаж, Блицкриг, гүн тулаан гэсэн стратегиуд хөгжсөн үе	<ul style="list-style-type: none"> • Дэлхийн хоёрдугаар дайн • Солонгосын хойгийн дайн • Вьетнамын дайн • Персийн булангийн дайн • Афганистаны дайн • Иран- Иракийн дайн
IV үеийн дайн	Төвлөрсөн биш байдлаар явагдах болсон, улс төр-цэрэг, цэрэг-энгийн харилцаа өөрчлөгдсөн, улс биш тоглогч-босогчдын бүлэг, хувийн цэргийн гэрээт байгууллага, хагас цэрэгжүүлсэн байгууллагууд энэхүү дайнд гол үүрэг гүйцэтгэх болсон, терроризм гарч ирсэн.	<ul style="list-style-type: none"> • Хезболла бүлэглэлийн ажиллагаа • Шри-Ланкын Тамилийн барсуудын хөдөлгөөн • Аль-Каида бүлэглэл • Исламын улс

V үеийн дайн	Нийгмийн инженерчлэл, худал мэдээлэл тараах, кибер довтолгоо, хиймэл оюун ухаан, бүрэн автомат систем зэрэг кинетик цохилтгүй цэргийн ажиллагаагаар явагддаг дайн. “Мэдээлэл, ойлголт”-ын дайн гэж мөн томъёолох болсон.	<ul style="list-style-type: none"> • Крымийн хойгийн ажиллагаа • Орос-Украины дайн
VI үеийн дайн	Нэн өндөр цэцтэй, хэт авианы пуужин, робот хэлбэрийн зэвсгээр алсын зайнаас цохилт өгөх “хавьталгүй дайн” эсвэл төлөөллийн дайны хэлбэр. Өгөгдөл, тагнуулын мэдээлэл авах, мэдээ өгөгдлөөр удирдагчид, иргэдийн бодол санааг өөрчлөх асуудал гарч байна.	<ul style="list-style-type: none"> • Орос-Украины дайн

Эх сурвалж: Хятадын Үндэсний Статистикийн Товчоо.
<https://www.china-briefing.com/news/china-provincial-gdp-2022/>

3

СҮҮЛИЙН ҮЕИЙН ДАЙН, ЗЭВСЭГТ МӨРГӨЛДӨӨНИЙ ШИНЖ ЧАНАР, ОНЦЛОГ

Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт хамгийн том өөрчлөлт, хувьсгал авч ирсэн нь 1991 онд АНУ, НАТО-гийн тэргүүлсэн олон үндэстний цэргийн хүчний Кувейтийг Иракийн түрэмгийллээс чөлөөлөхийн төлөө явуулсан Персийн булангийн дайн буюу “Цөлийн шуурга” ажиллагаа байв.

“Цөлийн шуурга ажиллагаа” олон үндэстний цэргийн агаарын хүчний цохилтоор 1991 оны нэгдүгээр сарын 17-ны өдөр эхэлсэн бөгөөд гол онцлог нь агаарын цэргийн хүч болон нэн өндөр цэцтэй пуужингийн цохилтыг

“агаарын операц”-ийн хэмжээнд үе шаттайгаар, урьд өмнө байгаагүйгээр өргөнөөр явуулсанд оршино. “Цөлийн шуурга ажиллагаа” цэргийн урлагийн түүхэнд анх удаа “Агаарын довтолгооны ажиллагаа”¹ гэсэн бие даасан байлдааны ажиллагааны шинэ төрлийг гаргаж ирсэн юм. “Агаарын довтолгооны ажиллагаа”-г агаар-сансрын цэргийн хүчний бүх төрлийн нэгтгэл, анги, тэнгисийн цэргийн хүчний нисэх

¹ Агаар-сансрын хүчин, тэнгисийн цэргийн хүчний нэгтгэл, анги, агаарын довтолгооноос хамгаалах систем, тагнуул, радио электрон тэмцлийн нэгтгэл ангиудын хуурай замын цэргийн оролцоогүй явуулах байлдааны ажиллагаа

онгоц тээвэрлэгч хөлөг онгоцны цохилтын бүлэг, агаарын довтолгооноос хамгаалах систем, сансрын болон агаарын тагнуул, радио электрон тэмцлийн нэгтгэл ангиудын өргөн оролцоотойгоор дайсны улсын болон цэргийн удирдлагыг алдагдуулах, цэрэг-эдийн засгийн чадавхыг сулруулах, стратегийн давуу байдал олж авах зорилгоор явуулах болсон.

“Цөлийн шуурга ажиллагаа”-ны агаарын хүчний цохилтыг хоёр үе шаттай (нэгдүгээр шат 3 хоног, хоёрдугаар шат 35 хоног)-гаар зохион байгуулсан байдаг. Нийт 38

**Зураг 4. “Цөлийн үнэг” агаарын довтолгооны ажиллагаа
(1998 оны 12 дугаар сар)-ны цувраажилт**



хоногийн турш тасралтгүй, эрчимтэй явуулсан агаарын хүчний цохилтод 2300 нэгж байлдааны нисэх онгоц оролцож, 100 гаруй мянган удаагийн нислэг² хийж Иракийн цэргийн болон стратегийн ач холбогдолтой энгийн объектуудад цохилт өгчээ.

Агаарын довтолгооны ажиллагааны үндсэн хэсэг нь Агаар-пуужингийн хүчтэй цохилт (массированные ракетно-авиационные удары МРАУ³) юм. АНУ, НАТО-гийн Ирак, Югославт явуулсан байлдааны ажиллагааны үндсэн хэсэг болсон агаарын довтолгооны ажиллагааны цувраажилт нь тус бүр 2-3 цагийн турш үргэлжлэх 7 хүртэлх удаагийн агаар-пуужингийн хүчтэй цохилт (АПХЦ)-оос бүрдэж байв. Ажиллагааны эхний өдрүүдэд 2-3 удаа, дараагийн

өдрүүдэд 1-2 удаагийн АПХЦ өгч, завсарт нь 6-8 цагийн туршид системтэй байлдааны ажиллагаа (СБА) явуулж байв.

Агаарын довтолгооны ажиллагааны бас нэгэн сонгодог жишээ нь 1998 онд Иракийн эсрэг явуулсан “Цөлийн үнэг ажиллагаа” байв.

- Нийт үргэлжилсэн хугацаа: 6 хоног
- Хөлөг онгоцноос харвасан далавчит пуужин (ДП): 180 нэгж
- Нисэх онгоцноос харвасан далавчит пуужин: 24 нэгж
- Нисэх онгоц: 300 нэгж
- Нисгэгчгүй нисэх аппарат: 40 нэгж
- Нийт устгасан объект: 70 (үүнээс цэргийн-50, Цэрэг-аж үйлдвэрийн-15)

Дэлхийн хоёрдугаар дайн болон түүний дараагаар болсон дайн зэвсэгт мөргөлдөөнд хуурай замын цэргийн давшилтын

ажиллагаа эхлэхийн өмнө агаарын болон артиллерийн цохилтыг цөөн хэдэн цаг, минутын турш явуулдаг байсан бол “Цөлийн шуурга ажиллагаа”-ны үед агаарын хүчний ажиллагаа, пуужингийн цохилтыг 38 хоногийн турш тасралтгүй, эрчимтэй явуулж хуурай замын цэргийн ажиллагаа хоёрдугаар сарын 24-ний өдөр эхэлж, ердөө дөрөв хоног үргэлжилж дуусан тул “100 цагийн ажиллагаа” хэмээн нэрлэсэн байдаг.

“Цөлийн шуурга” ажиллагааны явцад хиймэл дагуулын навигацийн систем, нисгэгчгүй нисэх аппарат, АДЭХ “Патриот” систем, “ухаалаг” галт хэрэгсэл, “Томахоок” далавчит пуужин, F-117 үл үзэгдэгч нисэх онгоц гэх мэт олон төрлийн өндөр цэцтэй шинэ зэвсэг, техник ашигласан нь XXI зууны эхэн үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарыг тодорхойлох болсон юм.

Югославын дайн буюу НАТО-ийн эвслийн 1999 онд явуулсан “Холбоотны хүч” агаарын довтолгооны

² <https://jalopnik.com/operation-desert-storm-by-the-numbers-on-its-25th-anniv-1753347671>

³ <https://cyberleninka.ru/article/n/primenenie-potentsialnym-protivnikom-vysokotochnyh-sredstv-porazheniya-po-aerodromam-bazirovaniya-operativno-takticheskoy-avitsii>

Зураг 5. Югославт явуулсан “Холбоотны хүч” агаарын довтолгооны ажиллагаа (1999 оны гуравдугаар сарын 24-өөс зургаадугаар сарын 10)-ны цувраажилт



ажиллагаа 78 хоногийн турш зөвхөн агаар-пуужингийн хүчтэй цохилтоор явагдсанаараа онцлогтой байв. Агаарын довтолгооны ажиллагааны явцад нийт 35219 удаагийн байлдааны нислэг хийж, АНУ, Их Британи, Франц, Германы тэнгисийн болон агаарын цэргийн хүчин нийт 22 удаагийн агаар-пуужингийн хүчтэй цохилт (АПХЦ) өгсөн байдаг.

НАТО-гийн Югославт явуулсан агаарын довтолгооны ажиллагаа нь хуурай замын цэргийн оролцоогүй, “хавьталгүй дайн” (безконтактная война) буюу зайнаас дайтах байлдааны ажиллагааны эрин үеийг нээснээрээ онцлогтой юм.

“Иракийн эрх чөлөө ажиллагаа” буюу Иракийн II дайн 2003 оны гуравдугаар сарын 19-ний өдөр эхэлж, эхний шат нь тавдугаар сарын 01-ний өдөр дууссан (АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш дайн дууссаныг зарласан) гэдэг ч дайн үнэн чанартаа 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл найман жил гаруй хугацаанд үргэлжилсэн юм.

Дайны гол зорилго нь Саддам Хусейны дэглэмийг түлхэн унагааж Иракт ардчилал, эрх чөлөө олгох, ҮОХЗ-ийг олж устгах, террорист бүлэглэлүүдийг устгах гэсэн цэрэг-стратегийн гэхээсээ илүү цэрэг-улс төрийн зорилго агуулж байв.

Иракийн дайнд АНУ, НАТО-ийн зарим орны тусгай хүчний цэргийг түлхүү ашигласнаараа онцлогтой бөгөөд эсрэг тал нь партизаны дайн, террорист ажиллагаа (амиа золиослогч, алсын удирдлагатай тэсрэх бөмбөг)-г хослуулан цэргийн том хүчний эсрэг ассиметрик дайны⁴ хэлбэрээр үр дүнтэй тэмцэл явуулж байв.

Дайны бас нэгэн онцлог нь байлдааны ажиллагааны эхний шатанд дэлхийн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээллийн дайныг хүчтэй явуулж, “Олон улсын терроризмын

⁴ Цэргийн хүч тэнцвэргүй (тэгш бус) эвсэл огт өөр стратеги, тактик ашиглаж буй сөргөлдөгч талуудын зэвсэгт тэмцэл

эсрэг тэмцэл”-д 40 гаруй улсыг нэгтгэсэн явдал юм. Мөн хиймэл дагуулын чиглүүлэгчтэй өндөр цэцтэй зэвсэг зэрэг олон тооны шинэ зэвсгийн (цацраг идэвхт хольц, гол төлөв шавхагдсан уран (U-238) агуулсан хориотой төрлийн зэвсгийг ашигласан байж болзошгүй) туршилт явагдсан байна.

Энэ дайны үр дүнд Иракт олон жил үргэлжилсэн хүмүүнлэгийн хямрал, тогтворгүй байдал үүсэж, өнөөдөр ч үргэлжилж байна. Иракийн дайны дараа Ойрх Дорнодод Исламын улс бүлэглэл хүчирхэгжиж идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон.

Афганистаны дайн 20 жил (2001-2021 он) үргэлжилсэн бөгөөд улс төрийн анхны зорилго, хэрэглэсэн зэвсэг, сөргөлдөгч талуудын байлдааны тактик зэрэг олон зүйлээрээ Иракийн дайнтай төстэй юм.

Сирийн дайн цэргийн болон цэргийн бус шинж чанар бүхий уламжлалт болон уламжлалт бус дайны

хэлбэр хосолсон шинж чанар агуулснаараа онцлогтой. Дайны эхний шатанд АНУ, Барууны орнуудын зүгээс Сирийн дотоод зөрчлийг сөрөг хүчний зэвсэгт тэмцэл болгон хувиргаж, мэдээллийн дайныг идэвхтэй явуулах замаар босогчдыг зохион байгуулалтад оруулж, улмаар хилийн чанадаас санхүүжилттэй террорист бүлгүүдтэй холбож Башар Асадын Засгийн газрын эсрэг тэмцэл болгон хувиргах дарааллаар улс төрийн тогтолцоог өөрсдийн ашиг сонирхолд нийцүүлэн өөрчлөх бодлого хэрэгжүүлсэн байдаг.

ОХУ, Сирийн Ерөнхийлөгч Башир Асадын засгийн газрыг дэмжих зорилгоор 2015 оны есдүгээр сараас эхлэн өнөөг хүртэл цэргийн ажиллагаа явуулж буй бөгөөд 2018 оны байдлаар агаар-сансрын хүчний 90 гаруй хувийг Сирид “дадлагажуулж”, агаарын довтолгооны ажиллагаа явуулах дадлага, сургуулилтыг бодит байдал дээр хийсэн байна.

Ливийн дайн өнгөт хувьсгалын тавилтаар эхлүүлсэн арга ажиллагаа, хэрэгжүүлсэн дараалал зэргээрээ Сирийн дайнтай ижил юм. Дайны үеэр нислэггүй бүс байгуулахын хамт НАТО-гийн гишүүн орнуудын хувийн цэргийн компаниуд, сөрөг хүчний

зэвсэгт нэгтгэлүүдийн харилцан ажиллагаатайгаар тэнгисийн бүслэлтийн ажиллагааг нэгэн зэрэг явуулснаараа онцлогтой байв.

“Карабахын хоёрдугаар дайн” буюу Азербайжан, Армени хоорондын дайн 2020 оны есдүгээр сард эхэлж 44 хоног үргэлжилсэн бөгөөд Азербайжаны тал дайралтын болон амиа золиослогч нисгэгчгүй нисэх аппаратыг үр дүнтэй ашигласан онцлогтой байв.

“Орос-Украины дайн” нь орчин үеийн байлдааны ажиллагаанд өндөр цэцтэй зэвсэг, агаар, пуужингийн цохилт чухал хэдий ч эцсийн үр дүн хуурай замын цэргийн ажиллагаанаас шалтгаалсан хэвээр байгааг нотолсон, сүүлийн 30 жилийн хугацаанд явагдаж байгаагүй хуурай замын цэргийн том ажиллагаа болж байна.

Дайны улс төрийн зорилго нь Киевийн дэглэмийг өөрчилж, Украиныг төвийг сахисан статустай болгож, улмаар Оросын хараат улс болгоход оршиж байгаа бол цэрэг-стратегийн зорилго нь Крымийн хойг, Украинд бүрэн хяналтаа тогтооход чиглэгдэж байна. АНУ, НАТО-ийн цэрэг-улс төрийн зорилго нь Оросын цэргийн хүчийг бүрмөсөн

сулруулах замаар улс төрийн хямралд хүргэхэд чиглэгдэж байгаа бол цэрэг-стратегийн зорилго нь мөн л Крымийн хойг, Украинд бүрэн хяналтаа тогтооход чиглэгдэж геостратегийн ашиг сонирхол давхцаж байгаа нь дайны үндсэн шалгаан болсон.

Энэ дайнд тийрэлтэт артиллерийн систем, нисгэгчгүй нисэх аппарат чухал үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд хэт авианы шинэ зэвсэг анх удаа хэрэглэсэн (Оросын тал 2022 оны гуравдугаар сарын 18-нд Украины баруун хэсгийн Ивано-Франковск дахь зэвсгийн агуулахад хэт авианы «Кинжал» пуужингаар анх цохилт өгсөн) гэдгээрээ онцлогтой байна. Хэт авианы (гиперсоник) пуужин зэвсэглэлд нэвтэрснээр пуужингийн довтолгоо болон түүнээс хамгаалах системийн хооронд асар том орон зай үүсэж Оросын С-400, АНУ-ын “Пэтриот” зэрэг пуужингийн довтолгооноос хамгаалах хамгийн орчин үеийн гэгддэг системүүдийг үндсэнд нь “ажиллагаагүй” болгож, түрүүлж эзэмшсэн талд цэрэг-стратегийн давуу байдлыг бий болгож байна.

Орос-Украины дайнд дэлхий нийтийг талцуулах хэмжээнд хүргэсэн мэдээллийн дайн маш

хүчтэй явагдаж байгаа нь бас нэгэн онцлог болж байна.

Дээр дурдсан дайн, зэвсэгт мөргөлдөөний үйл явцад дүгнэлт хийхэд ХХ зууны сүүлч, ХХI зууны эхэн үед болсон дайн, зэвсэгт мөргөлдөөн дараах ерөнхий шинж чанарыг агуулж байна. Үүнд:

• **А. Цэрэг-улс төрийн агуулгаар:**

- Өмнө нь болж өнгөрсөн дайн, зэвсэгт мөргөлдөөн нь социалист, капиталист хоёр системийн геополитикийн тэмцлийн илрэл байсан бол орчин үеийн дайны улс төрийн болон цэрэг-стратегийн зорилго нь геостратеги, байгалийн баялаг, эрчим хүчний нөөцийн төлөөх өрсөлдөөнтэй холбоотой;
- Их гүрнүүд өөрсдийн геостратегийн ашиг сонирхолд байгаа улс, орон (Афганистан, Ирак, Югослав, Ливи, Сири, Египет, Украин)-ы улс төрийн тогтолцоог өөрчлөхийн тулд өнгөт хувьсгалаар дамжуулан, эсвэл шууд зэвсэгт түрэмгийлэл явуулах замаар зорилгодоо хүрсэн;
- Олон улсын цэргийн хүчирхэг эвсэл, холбоо байгуулах замаар цэрэг-

улс төрийн болон цэрэг-стратегийн нийтлэг зорилгоо хэрэгжүүлдэг механизм тогтсон;

- Тусгаартогтносон жижиг улсуудын газар нутаг, зарим субъектийг улс төрийн дарамт шахалт болон цэргийн хүчийг хослуулан хэрэглэж салган авч байгаа;
- Мэдээллийн дайн байлдааны ажиллагааны салшгүй нэгэн хэсэг болсон;
- Мэдээллийн давуу байдалтай болох зорилгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээг өргөнөөр ашиглах замаар хэрэгжүүлэх болсон;
- Хиймэл оюун ухааны т у с л а м ж т а й г а а р нийгмийн сүлжээ дэх худал мэдээллийг ард түмэнд нөлөөлөх зэвсэг болгон системтэйгээр ашиглах болсон;
- Тухайн улсын эрчим хүч, банк, эдийн засаг, мэдээллийн болон дэд бүтцийн бусад салбарт дайны бус цэргийн ажиллагаа явуулах болсноор дайн, энхийн том зааг, ялгаа арилсан. Үүний жишээ нь 2015 онд Ираны эрчим хүчний дэд бүтэц рүү кибернетик халдлага хийсний үр дүнг дурдаж болно.

• **Б. Цэрэг-стратегийн агуулгаар:**

- Агаарын хүчний болон нэн өндөр цэцтэй пуужингийн олон хоног тасралтгүй, эрчимтэй үргэлжилсэн а ж и л л а г а а г а а р ц э р э г - с т р а т е г и й н а ч холбогдолтой объектууд, дэд бүтцэд цохилт өгч хүчтэй эсэргүүцэх чадваргүй болтол туйлдуулсны дараа хуурай замын цэргийн ажиллагаа явуулах болсон;
- Хэдийгээр өндөр цэцтэй зэвсэг хэрэглэж байгаа ч дайн, зэвсэгт мөргөлдөөний явцад иргэний зориулалттай дэд бүтэц, энгийн иргэд олноор өртөх болсон. Улс орны эдийн засгийг бүхэлд нь сүйрүүлж хямралд оруулдаг хүмүүнлэгийн хувьд “бохир” технологи хэрэглэх болсон;
- Хосолмол дайн (Hybrid Warfare)-ы хэлбэрт шилжсэн;
- Зарим тохиолдолд “хавьталгүй дайн” буюу зайнаас дайтах байлдааны ажиллагаа явуулж нисгэгчгүй нисэх аппарат зэрэг хиймэл оюун ухаан бүхий робот зэвсгийг ашиглаж байгаа;
- Кибер халдлагаар улсын болон цэргийн

удирдлагын системийг нь саармагжуулж цэрэг батлан хамгаалах, эрчим хүч, эдийн засгийн бүх салбарт асар их хохирол учруулах боломжтой болсон;

- Сөргөлдөгч талуудын зэвсэгт хүчний хөгжил, зэвсэглэл, техникийн хөгжлийн түвшин, хүчин чадал эрс ялгаатай байгаагаас ассиметрик шинж чанар давамгайлах болсон. Террорист ажиллагаа, тагнуул, хорлон сүйтгэх ажиллагаа, жижиг бүлгийн партизаны дайны хэв шинж “хэвийн” үзэгдэл болж байна;

- Зэвсэгт тэмцэл нь байлдааны ажиллагааны нэг театрын хүрээнд явагдаж байгаа ч өөр бүс нутгийн орнуудын цэргийн хүч шууд болон дам хэлбэрээр оролцох болсноор дайн, зэвсэгт мөргөлдөөн улам бүр глобал шинж чанарыг агуулах болсон;
- Дайн, зэвсэгт мөргөлдөөний эхний үе шатанд стратегийн санаачилгыг эхэлж авах нь төгсгөлийн үр дүнд нөлөөлөх болсон;
- Агаар цэргийн хүч, алсын тусгалтай өндөр цэцтэй пуужингийн зэвсэг дайн, зэвсэгт мөргөлдөөний эхний

шатанд гол үүрэг гүйцэтгэх байгаа ч эцсийн үр дүн хуурай замын цэргийн ажиллагаанаас хамааралтай хэвээр байна;

- Агаар-сансрын орон зай, далай, тэнгист явагдах байлдааны ажиллагааны үр дүнг хуурай замын цэрэг хэрхэн бататгахаас дайн, зэвсэгт мөргөлдөөний цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн зорилгодоо хүрэх эсэх нь тодорхойлогдох болсон;
- Радио электрон тэмцлийн ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа; зэргийг дурдаж болно.

4

ЦЭРГИЙН ЗЭВСЭГ, ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖЛИЙН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Одоо өрнөж буй Орос-Украины дайнд хэрэглэж буй зэвсэг, техник нь ихэвчлэн 2-4 дүгээр үед хамаарч байна. Тухайлбал, Оросын Т-72 танк, “Ураган-1М” тийрэлтэт артиллерийн систем 2 дугаар үеийнх бол Су-27 онгоц 4 дүгээр үеийн зэвсэглэлд хамаарна. Америкийн “Хаймарс” тийрэлтэт артиллерийн систем болон Германы Леопард-2 танк 3 дугаар үеийн зэвсэглэлд орно.

Энэ дайнд хамгийн орчин үеийн буюу зургаадугаар үеийн зэвсгээс Оросын хэт авианы “Кинжал” пуужинг хэрэглэсэн.

Ирээдүйн дайн ямар ч тохиолдолд өндөр технологид суурилсан байх нь тодорхой байна. Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, автономн систем, сансрын технологи, хэт авианы пуужин, дрон зэрэг технологийн хэрэглээ нь

дайн, тулаанд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон бөгөөд эдгээр технологийн хөгжүүлэлт, хэрэглээ нь цаашид мэдэгдэхүйц нэмэгдэх төлөвтэй байна. АНУ-ын Олон улс, стратегийн судлалын төвөөс гаргасан тайланд ирээдүйн дайн ялахын тулд “аюулгүй нөөц сүлжээ, квандын технологи, биоинженеринг, сансарт суурилсан технологи, хиймэл оюун ухаан,

Зураг 6. Ирээдүйн дайнд ялах онц чухал долоон технологи



Эх сурвалж: <https://www.csis.org>

өндөр хүчин чадалтай зай, робот” гэсэн 7 технологийг цаашид хөгжүүлж, эзэмших зайлшгүй шаардлагатай байгаа талаар онцолсон байна.

Хэт авианы пуужингийн зэвсэглэлийн технологийг хөгжингүй орнууд эрчимтэй хөгжүүлэх болсон. ОХУ гэхэд л “Сармат” пуужингийн систем, усан доорх нисгэгчгүй аппарат болон хэт авианы “Кинжал”, “Циркон”, “Авангард” зэрэг пуужингийн системийг хөгжүүлэн зэвсэглэлдээ хүлээн авч, Орос-Украины дайнд “Кинжал” пуужинг хэрэглэж, “Циркон”-оор тоноглогдсон “Адмирал Горшков” хөлөг онгоцыг








байлдааны жижүүрлэлтэд гаргасан.

АНУ нь 5-7 мах хурдтай, 6200 км хүртэл алсын тусгалтай “X-51A Waverider” хэт авианы далавчид пуужингийн систем, 5 мах хурдтай 2700 км хүртэл алсын тусгалтай LRHW (Long-Range Hypersonic Weapon) хэт авианы пуужингийн системийг тус тус зэвсэглэлд хүлээн авахаар төлөвлөж байна. АНУ-ын Штабуудын нэгдсэн хорооны дарга генерал М.Милли 2021 онд Конгрессын Батлан хамгаалахын худалдан авалтын дэд хорооны асуулгад Мах 15 хурдтай хэт авианы пуужин туршилтын шатанд яваа гэж мэдэгдсэн байна.

БНХАУ хэт авианы пуужингийн хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлж 2014 онд долоон удаагийн туршилтынхаа эхнийхийг хийсэн бөгөөд Мах 10 хурдтай, дунд зайн буюу 1800-2500 км-ийн алсын тусгалтай DF-17 пуужингийн системийг зэвсэглэлдээ авсан байна.

Их Британи, Франц хамтран 2011 оноос хойш Хатан хааны Тэнгисийн цэргийн хүчин болон Францын Тэнгисийн цэргийн хүчний хуучирсан Nauroon болон Exocet-ийг боловсронгуй болгох замаар хэт авианы “Perseus” пуужинг бүтээх төслийг 2011 оноос хэрэгжүүлж эхэлжээ.

Зураг 7. Хөгжингүй орнуудын хэт авианы пуужин

ОХУ	АНУ	БНХАУ
 <p>SARMAT: Олон шатлалт шөвгөн түлш эер ажилладаг тив алагсагч баллистик пуужин 5 дахь үеийн стратегийн пуужингийн цогцлолбор, хурд=28 мах (нэг секундэд ойролцоогоор 7,5 км), алсын тусгал 18000 км, 2022 онд зэвсэглэлд хүлээн авна.</p>	 <p>X-51A Waverider: Хэт авианы далавчигч пуужин, хурд=5-7 мах (нэг секундэд ойролцоогоор 2 км), алсын тусгал 6200 км, 2022 онд зэвсэглэлд хүлээн авна.</p>	 <p>DF-ZF: Алсын тусгалтай хэт авианы зэвсэг, хурд=10 мах (нэг секундэд ойролцоогоор 1.7 км), алсын тусгал 1800-2500 км</p>
 <p>КИНЖАЛ: Хэт авианы нислэгийн пуужингийн цогцлолбор, хурд=12 мах (нэг секундэд ойролцоогоор 4 км), алсын тусгал 2000 км, 2021 онд алсын Кинжалар зэвсэглэсэн цэргийн анги (Хороо)-г байгуулсан.</p>	 <p>LRHW: Алсын тусгалтай хэт авианы зэвсэг, хурд=5 мах (нэг секундэд ойролцоогоор 1.6 км), алсын тусгал >2700 км, 2023 онд зэвсэглэлд хүлээн авна.</p>	
<p>ЦИРКОН: Хөлөг онгоцны эсрэг хэт авианы далавчигч пуужин, хурд 8 мах (нэг секундэд ойролцоогоор 2,8 км), алсын тусгал 500 км, 2020 оны 10 дугаар сараас байдалны жижүүрлэлтэд хүлээн авсан.</p> 		
<p>АВАНГАРД: Удирдлагатай байдалны цэнэгт хошуутай тив алагсагч пуужин, хурд=28 мах (нэг секундэд ойролцоогоор 7,5 км), алсын тусгал > 6000 км, 2019 оны 12 дугаар сараас байдалны жижүүрлэлтэд хүлээн авсан.</p> 		

Хиймэл оюун ухааны чиглэлд гарч буй дэвшил нийгмийн сүлжээний сөрөг нөлөөг нэмэгдүүлж улмаар “олон нийтийг бужигнуулах зэвсэг” хэмээх шинэ төрөлд тооцогдох болсон. Энэ хандлага цаашид ч улам эрчимжих бөгөөд гарах сөрөг үр дагаврыг төсөөлөх боломжгүй болж байгаа нь улс орны болон хувь хүн, нийгэм, төрийн аюулгүй байдалд эрсдэл сорилт дагуулж байна. Хүн төрөлхтний түүхийн дийлэнх хугацаанд технологийн инновац эерэг үр дүнг дагуулж ирсэн байдаг ч өнөөдөр хиймэл оюун ухаанд суурилсан технологийн дэвшил нийгэм дэх

итгэлцлийг сулруулж, авторитар удирдагч болон популистуудад ашиглагдаж, бизнес, зах зээлийг эвдэх нөлөөллийг бий болгож байна.

Хиймэл оюун ухааны зарим (Chat GPT болон Stable Diffusion зэрэг) дэвшлүүд нь хүмүүсийг ашиглах, улс төрийн хямрал үүсгэх хангалттай хүчийг бий болгож байна. Гол аюул нь: бужигнуулах технологийн тархах таатай орчин нь нийгмийн сүлжээ болж байгаа тул ямар нэг контент үүсгэхэд ямар ч шалгуур байхгүй учраас контентын тоо, хэмжээ нэмэгдэж, иргэдийн хувьд худал мэдээллээс үнэнийг ялгах боломжгүй болж

буйд оршиж байна. Худал мэдээлэл гэрлийн хурдаар өсөж аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн бүх салбарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Дайнд шинжлэх ухаан технологийн хөгжлийг ашигласнаар учруулах хөнөөл, хурд, хүч нэмэгдэж, эдгээрээс шалтгаалан үргэлжлэх хугацаа нь ч мөн өөрчлөгдөх хандлагатай болж, дайн, зэвсэгт мөргөлдөөн физик-газар зүйн орон зайнаас хальж кибер, сансрын оронд зайд хүрээгээ тэлэх тодорхой болов. Өндөр технологийн дайнд ялах нь 1. технологийн давуу тал, 2. байлдааны арга тактик, 3. хүчний

Зураг 8. Олон нийтийг “бужигнуулах” зэвсэг



Эх сурвалж: <https://www.eurasiagroup.net/issues/top-risks-2023>

зохистой бүтэц зэргээс илүү шалтгаалах төлөвтэй байна. Технологийн магнатууд гэгддэг Элон Маск, Билл Гейтс нар хиймэл оюун ухаан хүн төрөлхтний оршихуйд аюул учруулна гэж анхааруулж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин технологид тэргүүлсэн нь дэлхийг удирдана гэж хэлсэн байдаг нь ирээдүйн дайны шинж чанарыг тодорхойлох бас нэгэн өгөгдөхүүн болж байна. БНХАУ гэхэд л 2030 он гэхэд хиймэл оюун ухаанаар дэлхийд тэргүүлэгч болно

гэсэн стратегиа албан ёсоор зарлаж, түүнийг дайтах урлагтаа нэвтрүүлэх болов.

Дайн, энхийн ялгаа зарим талаар бүдгэрч тайван цагт дайны бус цэргийн ажиллагаа системтэй явуулж зөвхөн цэргийн хүчээр биш улс орны бүх төрлийн хүч хэрэгслийг ашиглан хосолмол дайн (Hybrid Warfare), саарал бүсийн мөргөлдөөн (Gray zone conflict)-ыг явуулах болов. Саарал бүсийн мөргөлдөөн буюу дайны тод жишээ нь БНХАУ-ын зүгээс Тайванийн эсрэг явуулж буй

үйл ажиллагаа бөгөөд энэ нь ХАЧА-ийн “хязгаарлалтгүй дайн” (unrestricted warfare), “гурвалсан дайн” -ны стратегитай нийцэж байгаа юм.

Мөн орчин үеийн дайныг илүү Сүлжээнд тулгуурласан, Chaoplex warfare шинж чанартай байна хэмээн таамаглаж байна. Chaoplex гэдэг нь Chaos (хямрал, эмх замбараагүй байдал) complex (ээдрээтэй) гэсэн хоёр үгний нийлмэл бөгөөд ирээдүйн дайны шинжийг ийм байдлаар тодорхойлж буй юм.

Хүснэгт 2. Дайн, зэвсэгт мөргөлдөөний цаашдын чиг хандлага

д/д	Дайн, зэвсэгт мөргөлдөөний цаашдын чиг хандлага
1	Мэдээллийн дайны ач холбогдол улам нэмэгдэж, хиймэл оюун ухаан ашигласан худал мэдээллийг системтэйгээр тарааж, ард түмний ой санамжид нөлөөлөх ажиллагаа явуулах замаар үндэсний дархлаа, сөрөн гэсвэрлэх чадварыг сулруулах;
2	Өнгөт хувьсгал, төрийн эргэлтийн технологи ашиглан улс, орны дотоодод эмх замбараагүй байдал үүсгэх замаар нөлөөллөө тогтоох. Улмаар хямралт байдлыг тогтворжуулж, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах халхавчаар цэргийн хүч оруулах;
3	Геостратегийн ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор аль нэгэн улс, орныг “террорист улс”, “олон улсын аюулгүй байдалд заналхийлж байгаа”, “үндэсний эв нэгдлийг хагалан бутаргагч дайсан” гэх мэт шалтгаанаар олон улсын цэргийн эвсэл, холбоо байгуулж түрэмгийлэл үйлдэх;
4	Үндэстэн, шашин хоорондын зөрчил, сөргөлдөөнийг дэвэргэх замаар дайн өдөөж, зэвсэгт бүлэглэл оруулж, улс орны зарим субъектийг тусгаарлах, өөрийн харьяанд оруулах;
5	Дайны бус цэргийн ажиллагаа системтэй явуулж зөвхөн цэргийн хүчээр биш улс орны бүх төрлийн хүч хэрэгслийг ашиглан хосолмол дайн (Hybrid Warfare), саарал бүсийн дайн (Gray zone conflict)-ыг явуулах. Үүнтэй холбоотойгоор зэвсэгт мөргөлдөөн хэзээ үүсэхийг урьдчилан тааварлахад бэрхшээлтэй болж буй;
6	Физикийн шинэ зарчимд суурилсан, цөмийн зэвсэгтэй дүйцэхүйц хор хөнөөлтэй зэвсгийн шинэ систем ашиглах;
7	Агаар-сансрын орон зайд зэвсэгт тэмцэл өрнүүлэх, олон хоног үргэлжилсэн агаарын хүчний болон өндөр цэцтэй пуужингийн цохилтоор стратегийн ач холбогдолтой дэд бүтцийн системүүдийг устгаж эсэргүүцэх чадваргүй болгосны дараа агаарын десант, тусгай хүчний нэгтгэл ангиудын оролцоотой хуурай замын цэргийн ажиллагаа явуулах;
8	Нисгэгчгүй нисэх аппарат гэх мэт алсын удирдлагатай робот хэлбэрийн зэвсгийн технологиор “Алсын удирдлагатай дайн” явуулах;
9	Өндөр цэцтэй, цахилгаан соронзон, лазер, хэт авианы зэвсэг зэрэг шинэ төрлийн зэвсэг хэрэглэх;
10	Тавигдсан зорилгодоо хүрэхийн тулд газар, далай, агаар, сансарт ноёрхож стратегийн санаачилгыг гартаа авах;

5

ДҮГНЭЛТ

Дэлхийн хүн амын хурдацтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн баялгийн хомсдол, геополитикийн сөргөлдөөн,

эрх мэдлийн хуваарилалт зэргээс үүдэлтэй зөрчил тэмцэл оршин байгаа цагт дайн үргэлжид хамт байж, хүн төрөлхтний хөгжил

дэвшилтэй зэрэгцэн тэмцлийн арга хэлбэр, шинж чанар нь улам боловсронгуй болж, орон зайн хувьд эх дэлхийгээс нэгэнт хальж

сансрын орон зайд тулалдаан явагдах түвшинд хүрээд байна.

Сүүлийн үед их гүрнүүдийн геополитикийн ил,далдөрсөлдөөнэрчимжиж өөрсдийн геостратегийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор жижиг улс орнуудыг цэргийн хүчээр түрэмгийлэх хандлага гарч байгаа энэ цаг үед НҮБ сөргөлдөөнийг зохицуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх субъект болж чадахгүй байгаа нь хөгжиж буй орнуудын аюулгүй байдалд тулгарах аюул, эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Манай улсын цэрэг-улс төрийн гадаад орчин эмзэг, тогтворгүй, хөрш орнууд төрийнхөө бодлогоор батлан хамгаалах чадавхаа бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол өгч, шаардлагатай тохиолдолд хилийн чанадад өөрийн эрх ашгийг цэргийн хүчээр хамгаална гэдгээ аюулгүй байдлын бодлогын баримт бичгүүддээ тусгаж, улмаар хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээнүүд авч байна.

Өдгөө дайн болон энх тайвны зааг ялгаа бүдгэрч, уламжлалт дайн болон тайван цагийн дундын цаг хугацааны орон зай удаан үргэлжлэх болсон бөгөөд үүнийг “саарал бүсийн зөрчил” хэмээн нэрлэх

болжээ. Технологийн хөгжилд тулгуурласан цэргийн бус тэмцлийн арга хэлбэр нь урд өмнө төсөөлж байгаагүй, аюул, занал учруулж, зарим тохиолдолд хүч хэрэглэх шинжтэй болсноор тайван байсан улс орныг богино хугацаанд дотоодын хямралд оруулж байна. Үүнтэй холбоотойгоор нийгмийн сэтгэл зүйд шууд болон хиймэл оюун ухаанаар дамжуулан нөлөөлөх мэдээллийн дайны үүрэг роль нэмэгдэж, мэдээллийн давуу байдал олж авах явдлыг байлдааны ажиллагааны зайлшгүй нөхцөл хэмээн үзэх болжээ.

Орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил нь жам ёсоор юуны түрүүнд цэргийн салбарт нэвтэрч байгаагаас үүдэн сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд дэлхий дахинд болж өнгөрсөн, одоо үргэлжилж байгаа дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанарт томоохон өөрчлөлтүүд гарч байна. Ирээдүйн дайн, зэвсэгт мөргөлдөөнд хосолмол дайны шинж чанар давамгайлах төлөвтэй байна. Цаашид шинжлэх ухаан технологийн хамгийн сүүлийн үеийн ололтыг нэвтрүүлсэн өндөр цэцтэй, хэт авианы буюу гиберсоник пуужин, дрон, роботик систем, робот, хиймэл оюун

ухаан, лазер, төвлөрсөн энергийн зэвсгийн систем, кибер, мэдээллийн орон зайг сөргөлдөөнд өргөнөөр ашиглах төлөвтэй болов.

Аюулгүй байдлын шинэ бодлого, цэрэг-стратегийн шинэ сэтгэлгээ, шинэ санаа, технологи, зэвсэглэлийн өнөөгийн эрин үед орчин үетэйгээ хөл нийлүүлж чадаагүй улс дайнд ялагдах нь тодорхой юм. Өөрөөр хэлбэл технологи өндөр хөгжсөн улс орнууд давуу байдлаа ашиглан бусдад хяналтаа тогтоож, харин жижиг, буурай орнууд бараг хамгаалалтгүй болох эрсдэл тулгарч байна.

Бидний хувьд цэргийн хэргийн онолын хөгжлийн өнөөгийн байдал, орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний шинж чанар, зэвсэглэл, техник, технологийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг судалж, нисгэгчгүй нисэх аппарат гэх мэт робот хэлбэрийн зэвсэг зохион бүтээх болон тэдний эсрэг тэмцэл явуулах технологийг хөгжүүлэх үндэсний боловсон хүчнийг бодлогоор бэлтгэх, цэргийн сургалт бэлтгэлийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн чанаржуулах, цэргийн тагнуул, кибер аюулгүй байдал, радио электрон тэмцлийн анги, салбаруудыг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.